



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 6 сарын 28 өдөр

Дугаар А/109

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Төрийн албаны тухай Монгол улсын хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, Төсвийн тухай Монгол улсын хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам /код 136/”-ын 136.4.2-ийн “в”, 136.5.2-ын “г” дэхь заалт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соён гэгээрүүлэх ажил зохиох” /код 939.2.5e/, цагдаагийн газрын дотоод журмын 8 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ардын хувьсгалын түүхт 96 жилийн баяр наадмын угтаж “Хан Хэнтий аварга” дэвжээний бөхчүүдтэй хамтарсан бэлтгэлд гарсан Монгол улсын “Арслан” цолтой тус цагдаагийн газрын Батноров сумын цагдаа, цагдаагийн ахмад Энхтөгсийн Оюунболдын бэлтгэлжилтийн үеийн хоолны зардалд зориулж байгууллагын туслах аж ахуйгаас 3 /гурван/ хонь олгосугай.

2. Хоолны зардалд нийт 3 /гурван/ толгой мал олгож зарлагадахыг цагдаагийн газрын туслах аж ахуйгаас зарцуулахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.

4. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Ж.БОЛД

